




АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2019/03






ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 78.7 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 26.4 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 5.4 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100.0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Оны эхний 3 сард 394 эхээс 396 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.5 хувиар буюу 62 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 138 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор буюу 0.7 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 4.1, нас баралт 1.4 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 2.7 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2,

нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 6 гарч мянган амьд төрөлтөд 15.2 ногдож байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 14 нь буюу 135 хүн халдварт өвчнөөр өвчилсөн бөгөөд Эрдэнэбулган (32), Булган (18), Хангай (16), Тариат (14), Хототнт (14) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 29,3 хувь нь салхин цэцгээр, 34,1 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 13,8 хувь нь сүрьеэгээр, 22,8 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеэс 8.9 хувиар буюу 12 тохиолдлоор өндөр байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

4 дүгээр сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхитэй хайж байгаа 1225 ажилгүй хүн байгаагийн 48.2 хувь нь буюу 591 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 209 ажилгүйчүүд

ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 14.4 хувиар багассан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.0 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 185 нь дээд, 62 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 908 нь бүрэн болон бүрэн бус дунд, 58 нь бага боловсролтой хүмүүс байна.

3 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 300 хүн шинээр бүртгүүлж, 371 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 68 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 3 сард аймгийн дүнгээр 118 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган 27, Хотонт 20, Хайрхан 7, Батцэнгэл 6, Булган 6, Жаргалант 6, Өндөр-улаан 6, Цэцэрлэг 6, Цэнхэр 6, Эрдэнэмандал 5, Өлзийт 5, Хашаат 5, Өгийнуур 4, Тариат 3, Цахир 2, Хангай 2 ажлын байрыг тус тус бий болгосон бол Төвшрүүлэх, Чулуут, Ихтамир сумдад шинэ ажлын байр бий болгоогүй байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 3 сард 14.4 тэрбум төг, зарлага 14 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 1759.5 сая төг буюу 12.2 хувиар, зарлага 1940.8 сая төг буюу 13.8 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 1759.5 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 13 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 15.6 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 33.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 12.2 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 15.7 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 7.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 31.9 хувиар өссөн нь шууд нөлөөлөв.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 13.1 мянган хүнд 12.6 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 748 хүнд 482.4 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 3 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 29.8 мянган хүнд 4163 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 44.7 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 55.3 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 55.1 хувийг халамжийн тэтгэврээр, 31.1 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 13.8 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон бусад хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц






ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд 65 хүн гэмт хэрэгт холбогдож 172 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 46, өмчлөх эрхийн эсрэг 98, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 10, байгаль хамгаалах журмын эсрэг 4, бусад 14 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 45 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 418.7 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 9.9 хувийг бүлэглэж 10 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 180 хүнийг албадан саатуулж 59 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар




Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 18.6 хувиар буюу 27 тохиолдлоор өссөний дотор тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 38 хувиар буюу 27 тохиолдлоор тус тус өссөн байна.

Гэмт хэргийн гаралтыг сумдаар үзвэл Цахир суманд огт гараагүй, 18 болон түүнээс дээш насны арван мянган хүн амд ноогдох гэмт хэргийн тоогоор Жаргалант, Өндөр-Улаан,

Өлзийт, Чулуут, Хангай сумд 0.5-0.9 хувьтай байгаа нь хамгийн бага байгаа бол Эрдэнэбулган сум 5.4 хувьтай, Өгийнуур сум 5.3 хувьтай Хотонт, Батцэнгэл, Хайрхан, Цэнхэр, Ихтамир сумд 2.5 - 4.0 хувьтай байгаа нь хамгийн их гэмт хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2019 оны эхний 3 сард аймгийн төсөвт 4766.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4572.4 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 1578.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1384.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 87.7 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Эрдэнэбулган, Жаргалант, Өндөр-улаан, Төвшрүүлэх, Хайрхан, Хотонт сумд

хувиас 62.9 – 99.5 хувь биелүүлсэн бол Батцэнгэл, Булган, Өгийнуур, Өлзийт, Тариат, Хангай, Хашаат, Цэцэрлэг, Цэнхэр, Цахир, Чулуут, сумд 2.6-85.1 хувиар давуулсан биелүүлсэн байна. Ихтамир сум төсвийн орлогын төлөвлөгөөг 3 дахин давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар




Орлогыг нэр төрлөөр нь үзвэл агнуурын нөөц ашигласны төлбөр, ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр, ус рашааны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжаас бусад нэрийн орлогуудыг 100,0 хувиас 5,9 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 69.7 хувийг тусламжийн орлогоор, 27.2 хувийг орлогын албан татвараар, 0.8 хувийг өмчийн татвараар, 0.5 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 2.7 хувийг бусад албан татвараар, 2.7 хувийг татварын бус орлогоор, 0.4 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 65.1 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 230.1 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 3.9 сая төгрөг бүгд 299.1 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 15621.1 сая төгрөг байгаагийн 60.5 хувийг цалин хөлсөнд, 7.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 31.9 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 25.3 хувийг орон нутгийн засаг захиргаанд, 62.4 хувийг боловсролын салбарт, 10.9 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.8 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.5 хувийг хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 4964 сая төгрөгийг авч 6.1 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 3 сард банкууд 16.6 мянган иргэд, аж ахуй нэгжид 29.5 тэрбум төгрөгийн зээл олгосноос орон сууцны зээлийг 2 иргэнд 33 сая төгрөгийг олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 3 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 27.6 хувиар өсч, олгосон зээлийн хэмжээ 15.4 хувиар буурсан байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 29.1 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 8.9 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 3 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.9 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.6 хувиар, 2017 оны 12-р сарынхаас 1.8 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 2 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 373 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 16.9 хувийнх нь өсч, 6.4 хувийнх нь үнэ буурч 76.7 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас хорхой ааруул, тараг, үзэм, хиа, савласан сүү, ор хөнжлийн даавуу, гэрийн бүрээс, сойз, гар нүүрийн алчуур зэргийн үнэ 0.3-12.5 хувиар буурч харин үхэр, адуу,

ямааны мах, лууван, манжин, орны бүтээлэг, үхрийн сүү, шар будаа, ноосон цамц, хавар намрын гутал, трико зэргийн үнэ 0.1 – 14 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 14 хувийнх нь буюу 53 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 32.2 хувийнх нь буюу 120 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 53.8 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн дотор мах, 1-р зэргийн гурил, гурилан боов, цагаан будаа, амтат чинжүү, лууван, хатаасан жимс, эрээн даавуу, угаалгын нунтаг, даавуун оймс зэргийн үнэ 0.6-60.8 хувиар буурч харин кабелийн телевизийн хураамж, үхрийн мах, аарц, гоймон, гүрж ногоон цай, давс, дээлийн өргөн даавуу, жинсэн өмд,өвлийн гутал, далайн байцаа, автобусны тасалбарын үнэ, хивс зэрэг барааны үнэ 0.1- 75.0 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

4 дүгээр сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 20.2 хувь нь буюу 477.5 мянган эх мал төллөж гарсан төлийн 98 хувь нь буюу 467.9 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботго 100.0 хувь, унаганы 95.8 хувь, тугалын 95.6 хувь хурганы 98.5 хувь, ишигний 97.2 хувь нь бойжиж байна.


Төл бойжилтын хувь



Сумдаас Өгийнуур, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Батцэнгэл, Хашаат, Өлзийт, Өгийнуур, Чулуут, Цэцэрлэг сумд гарсан төлөө 99.0 – 100.0 хувиар бойжуулж байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 60.1 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 59 хувиар их, төлийн хорогдол 13.5 хувиар бага байна. Эхний улирлын байдлаар оны эхний мал 99.8 хувиар онд орж 0.2 хувь буюу 11.6 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 7.5 хувийг адуу, 12.4 хувийг үхэр, 41.6 хувийг хонь, 38.5 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Өгийнуур, Төвшрүүлэх, Хашаат, Хотонт сумдад малын хорогдол гараагүй бол Цэцэрлэг, Цэнхэр, Ихтамир, Жаргалант, Өндөр-Улаан, Цахир, Эрдэнэбулган сумдын оны эхний малын 0.3 - 0.6 хувь нь, Батцэнгэл, Булган, Тариат, Өлзийт, Чулуут, Эрдэнэмандал сумдын оны эхний малын 0.1 - 0.2 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр




2019 онд манай аймаг ойгоос 93.2 мянган м³ галын түлээ, 10.6 мянган м³ хэрэгцээний мод, бүгд 103.8 мянган м³

мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 3 сард 10 мянган м³ галын түлээ, 1.4 мянган м³ хэрэгцээний мод, бүгд 11.4 мянган м³ мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 49.3 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 3 сард оны үнээр 1954.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1791.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 5.6 хувиар илүү, борлуулсан бүтээгдэхүүн 3.0 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 674.3 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.2 хувиар их байна.



Нийт үйлдвэрлэлтийн 9.9 хувийг хүнс ундааны, 0,9 хувийг хэвлэлийн, 69.7 хувийг дулааны эрчим хүчний, 10.5 хувийг усан хангамж, 2.5 хувийг модон эдлэлийн, 6.4 хувийг гутал хувцасны, 0.1 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, бууз, дулаан, эсгий шаахай, монгол дээл, гэрийн модон тавилгын үйлдвэрлэл 1.8 – 151.1 хувиар нэмэгдлээ. Харин хэрчсэн гурил, монгол болон савхин гутал, түгээсэн цэвэр усны үйлдвэрлэлийн хэмжээ 1.8 – 22.4 хувиар буурсан байна. Тээврийн байгууллагууд 11.8 мянган зорчигч, 2.0 мянган тонн ачаа тээвэрлэн 5.5 сая хүн км, 0.9 сая ткм ажил гүйцэтгэн 202.4 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигчийн тоо 2.2 мянгаар буюу 15.7 хувиар буурсан байна.

Холбооны байгууллагууд 409 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 69.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.2 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

3 дугаар сард агаарын дундаж температур -8.6-оос -2.3 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хайрхан, Хашаат, Өгийнуур, Өлзийт, Батцэнгэл, Хотонт, Төвшрүүлэх, Жаргалант, Эрдэнэмандал сумдад 12.0 – 13.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөрүлаан, Тариат, Хангай, Чулуут сумдад -24.0-аас -25.0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Булган, Төвшрүүлэх сумдын нутгаар 9.4 – 12.8 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хайрхан, Өндөрүлаан, Эрдэнэмандал, Өгийнуур, Цахир сумдад 0.4 – 1.5 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2019.04.15